

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2022 оны 12 дугаар сарын 19

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг баримтлан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам” болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 8 дугаар хавсралтын дагуу байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулан, 01 дүгээр сарын 05-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 2 стратеги зорилго, 8 зорилтын хүрээнд 67 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Нийт арга хэмжээний 61 буюу 91% нь үр дүнтэй, 6 буюу 9% нь тодорхой үр дүнд хүрсэн байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1

Нийт арга хэмжээний тоо	Арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/			Нийт үнэлгээ /хувиар/
	Үр дүнтэй (100)	Тодорхой үр дүнд хүрсэн (70-100)		
		100%	90%	
67	61	3	3	98.2

Зорилт тус бүрээр ангилан үзвэл “Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх”, “Албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, ажиллах нөхцөл, бололцоог дээшлүүлэн, дэмжин ажиллах” зорилтод тусгагдсан арга хэмжээнүүд 91.1%, 94.3%-иар үнэлэгдэж бусад 6 зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд үр дүнтэй, бүрэн хэрэгжлээ. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ			Дундаж хувь
			100%	90%	70%	
1	2	3	4	5	6	7
1	Зорилт 1. Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний гуравдугаар зорилт)	9	5	2	2	91.1
2	Зорилт 2.	2	2			100

	Гадаадын иргэн, харьяатын эрх зүйн шинэтгэлийг нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн эрчимжүүлэх (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний нэгдүгээр зорилт)					
3	Зорилт 3. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үр дүнтэй механизмыг нэвтрүүлнэ. /ХЗДХС-ын ЭАХ-ний 2021-2024 ҮАСТ-ний 7.4/	12	12			100
4	Зорилт 4. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах	12	12			100
5	Зорилт 5. Байгууллагын үйл ажиллагааг оновчтой төлөвлөн, тайлагнах, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах	16	16			100
6	Зорилт 6. Гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаадын ижил чиг үүргийн байгууллагын хөгжлийн дэвшлийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний зорилт 4)	4	4			100
7	Зорилт 7. Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах	5	5			100
8	Зорилт 8. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, ажиллах нөхцөл, бололцоог дээшлүүлэн, дэмжин ажиллана.	7	5	1	1	94.3
Нийт		67	61	3	3	98.2

Дүгнэлт, зөвлөмж

2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 98.2% үнэлэгдсэн нь өмнөх онтой (94.8%) харьцуулахад 3.6%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ, түүний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшингийн уялдааг хангаж тайлагнаагүйгээс шалтгаалан үнэлэхэд хүндрэл үүсэж байна. Иймд шалгуур үзүүлэлт болон зорилтот түвшинг оновчтой тодорхойлж, түүнд нийцүүлэн бүрэн гүйцэд, алдаагүй, товч тодорхой тайлагнах;

Тодорхой үр дүнд хүрч, 70%-тай дүгнэгдсэн “Монгол Улсад ирж буй гадаад иргэдийг цахимаар бүртгэх буюу гар утасны мессеж (sms) үйлчилгээ ашиглан бүртгэх ажлыг зохион байгуулах”, “Монгол Улсад оршин сууж байгаа гадаадын

иргэнд цахим гарын үсэг олгох ажлыг зохион байгуулах” арга хэмжээний биелэлтийг жилийн эцэст бүрэн хангаж ажиллахын тулд үйл ажиллагааг эрчимжүүлэх, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, холбогдох байгууллагуудад дэмжлэг үзүүлэн түргэн шуурхай, нягт хамтран ажиллах;

“Өмнөд бүс дэх газрын албаны байрыг барьж ашиглалтад оруулах” ажлыг 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дахин тусгаж, хяналтад авч ажиллах, хөрөнгө оруулагч Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай уулзалт, хэлэлцээр зохион байгуулж, үлдэгдэл төсөв хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай.

---oOo---